



“МӨНХ ДААТГАЛ” ХХК -ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

**Сорогдог Финанс Аудит ХХК**

Хаяг: Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Өндөр  
цахир төв, 2 давхарт, 201 тоот  
Утас: 9910-4484, 9910-3149  
E-mail: [sorogdog.finance.audit@gmail.com](mailto:sorogdog.finance.audit@gmail.com)  
Огноо 2025.03.19 № 25/04

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**Дүгнэлт**

Бидний дүгнэлтээр, “Мөнх даатгал” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн өдрийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээн тайлангуудын бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу бодитойгоор илэрхийлсэн байна.

**Бид юунд аудит хийсэн талаар**

Дараах бүрэлдэхүүн бүхий санхүүгийн тайлангуудад бид аудит хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан
- Тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан
- Тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны өмчийн өөрчлөлтийн тайлан
- Тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны мөнгөн гүйлгээний тайлан, болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

## **Хараат бус байдал**

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм” болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

## **Санхүүгийн тайлангуудтай компанитайгаар удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУТ-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварыг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон компанийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

## **Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайлан хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй компанитай үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх

материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай компанитайгаар материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Компанийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гарахын тулд Компанийн доторх байгууллагууд болон бизнесийн үйл ажиллагаануудын санхүүгийн мэдээлэлтэй хамааралтай аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид компанийн аудитыг гүйцэтгэх болон нягтлан шалгах чиглэлээр хариуцлага хүлээдэг. Бид гаргасан аудитын дүгнэлтдээ зөвхөн хариуцлага хүлээнэ.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд багтдаг.



**МОНХ ДААТГАЛ ХХК**

**АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН – 2024 оны 12 сарын 31**

Төгрөгөөр	Тод руулга	2023.12.31	2024.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	4	420,638,039.01	1,487,993,209.14
Даатгалын авлагын дүн	5	1,910,376,230.81	2,158,216,465.88
Бусад санхүүгийн хөрөнгө	6	380,131,484.07	784,807,456.46
Бусад санхүүгийн бус хөрөнгө	7	77,225,090.24	975,236,304.35
Хөрөнгө оруулалт	8	7,274,315,232.11	8,998,223,551.64
Даатгалын хөрөнгө	9	1,760,143,220.08	2,664,198,445.53
Үндсэн хөрөнгө /Цэвэр/	10	4,361,775,936.50	6,196,955,176.26
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	11	351,471,900.00	351,471,900.00
		<b>16,536,077,132.82</b>	<b>23,617,102,509.26</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>			
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Даатгалын өглөг	12	-	237,210,465.15
Бусад санхүүгийн өр төлбөр	13	-	1,900,766,219.57
Бусад санхүүгийн бус өр төлбөр	14	333,677,637.96	251,825,374.51
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	15	6,289,496,008.89	8,059,587,079.86
Нөхөн төлбөрийн нөөц сан	16	1,987,282,512.13	2,871,507,914.40
		<b>8,610,456,158.97</b>	<b>13,310,897,053.49</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>			
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Хувийн өмч	17	5,000,000,000.00	7,500,000,000.00
Хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдэл	18	-	1,977,740,758.50
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		2,925,620,973.85	818,464,697.27
Эздийн өмчийн дүн		<b>7,925,620,973.85</b>	<b>10,296,205,455.77</b>
		<b>16,536,077,132.82</b>	<b>23,617,102,509.26</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>			

УЛААНБААТАР

**МОНХ ДААТГАЛ ХХК**

(Гарын үсэг)

М.Жалавдорж

Гүйцэтгэх захирал

(Гарын үсэг)

З.Баярсайхан

Ерөнхий нягтлан бодогч

**МӨНХ ДААТГАЛ ХХК**

**АУДИТЛАСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН – 2024 оны 12 сарын 31**

Төгрөгөөр	Тод руулга	2023.12.31	2024.12.31
<b>Даатгалын үйл ажиллагаа</b>			
Нийт хураамжийн орлого	19	17,367,996,033.13	23,800,208,697.51
Даатгалын хураамж буцаалт /-/	19	331,215,766.48	467,162,744.00
Давхар даатгалын хураамжийн зардал	19	1,248,575,625.05	1,864,006,019.22
<b>Даатгалын хураамж цэвэр орлого</b>	<b>19</b>	<b>15,788,204,641.60</b>	<b>21,469,039,934.29</b>
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт нийт дүнгээр	19	(2,405,831,055.94)	(1,770,091,070.98)
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсгийн өөрчлөлт	19	(253,738,728.46)	(253,450,293.08)
<b>Орлогод тооцсон хураамжийн цэвэр орлого</b>	<b>19</b>	<b>13,128,634,857.20</b>	<b>19,952,399,156.39</b>
<b>Нийт нөхөн төлбөр</b>	<b>20</b>	<b>5,670,193,558.30</b>	<b>9,441,443,265.00</b>
Давхар даатгалын хариуцах нөхөн төлбөр	21	236,187,781.55	324,211,299.76
Буруутай эдгээдийн хариуцсан нөхөн төлбөр	20	65,545,900.00	11,572,000.00
<b>Нөхөн төлбөрийн цэвэр зардал</b>	<b>20</b>	<b>5,368,459,876.75</b>	<b>9,105,659,965.24</b>
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	20	51,214,774.43	430,924,087.97
Нөхөн төлбөр нөөц сангийн давхар даатгагчид ноогдох хэсгийн өөрчлөлт	20	(218,149,168.14)	(159,290,982.45)
Учирч болзошгүй хохиролын нөөц сангийн өөрчлөлт	20	24,328,488.54	453,301,314.30
<b>Зардалд тооцсон нөхөн төлбөр</b>	<b>20</b>	<b>5,225,853,970.58</b>	<b>9,830,594,385.06</b>
Даатгалын гэрээний зардал	20	1,805,446,596.63	3,495,098,631.25
Давхар даатгалын комиссын орлого	21	29,920,370.84	27,901,574.00
Хөрөнгө оруулалтын орлого	22	-	1,011,745,822.50
<b>Даатгалын үйл ажиллагааны ашиг/ алдагдал</b>		<b>6,127,254,660.83</b>	<b>7,666,353,536.58</b>
Түрээсийн орлого	23	63,000,000.00	-
Хүүний орлого	23	1,046,892,111.67	2,962,172.36
Бусад орлого	23	-	34,515,999.31
Ерөнхий ба удирдлагын зардал	24	6,214,513,586.97	3,865,156,066.83
Борлуулалт, маркетингийн зардал	24	-	2,984,383,781.08
Санхүүгийн зардал	25	-	9,641,242.72
Бусад зардал	26	-	396,762,343.94
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	27	2,823,188.73	(1,471,231.18)
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	28	-	(9,924,016.48)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>1,025,456,374.26</b>	<b>436,493,026.03</b>
Орлогын татварын зардал	29	102,545,637.43	43,649,302.60
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>922,910,736.83</b>	<b>392,843,723.43</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>922,910,736.83</b>	<b>392,843,723.43</b>

Сорогдог

Финанс Аудит ХХК

9

Хуудлын төб . . . . .

**МОНХ ДААТГАЛ ХХК**  
**АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН – 2024 оны 12 сарын 31**

Төгрөгөөр	Тод руулга	Хувьцааг капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл		5,000,000,000.00	-	2,002,710,237.02	7,002,710,237.02
Өмчид гарсан өөрчлөлт		-	-	-	-
Тайлан үеийн үр дүн		-	-	922,910,736.83	922,910,736.83
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		5,000,000,000.00	-	2,925,620,973.85	7,925,620,973.85
2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл		5,000,000,000.00	-	2,925,620,973.85	7,925,620,973.85
Өмчид гарсан өөрчлөлт		2,500,000,000.00	-	(2,500,000,000.00)	-
Тайлан үеийн үр дүн		-	-	392,843,723.43	392,843,723.43
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-	1,977,740,758.50	-	1,977,740,758.50
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		7,500,000,000.00	1,977,740,758.50	818,464,697.27	10,296,205,455.77

**МОНХ ДААТГАЛ ХХК**

**АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН – 2024 оны 12 сарын 31**

Төгрөгөөр	Тод руулга	2023.12.31	2024.12.31
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>17,430,996,033.13</b>	<b>23,403,682,949.15</b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>		17,367,996,033.13	23,155,750,253.15
Даатгалын хураамжийн орлого			
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		-	247,932,696.00
Бусад мөнгөн орлого		63,000,000.00	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>17,681,613,065.18</b>	<b>24,288,891,579.71</b>
Ажилчдад олгосон		1,266,141,768.40	1,476,846,301.77
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		300,921,697.88	437,754,940.45
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө		888,512,286.42	664,200,445.00
Ашиглалтын зардалд төлсөн		4,914,818,611.55	4,953,700,977.84
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		1,248,575,625.05	2,486,082,910.47
Нөхөн төлбөрт төлсөн		5,461,049,872.43	9,092,655,452.97
Үүнээс: Сайн дурын даатгалын		3,631,737,791.43	6,010,151,986.97
Албан журмын даатгалын		1,829,312,081.00	3,082,503,466.00
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		1,504,855,110.68	2,414,095,293.00
Даатгалын зуучид төлсөн төлбөр		1,378,118,039.86	1,586,448,254.06
Даатгалын хохирол үнэлэгчидэд төлсөн төлбөр		5,121,000.00	41,486,500.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө		235,888,551.00	229,032,777.00
Хүүний төлбөрт төлсөн		-	-
Татварын байгууллагад төлсөн		146,394,735.43	439,352,983.15
Даатгалын хураамж буцаалт		331,215,766.48	467,162,744.00
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(250,617,032.05)</b>	<b>(885,136,630.56)</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>1,049,715,300.40</b>	<b>950,156,666.19</b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>		-	120,000,000.00
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		1,046,892,111.67	827,194,493.83
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		-	2,962,172.36
Хүлээн авсан хүүний орлого		-	-
Вальют ханш зөрүү олз/ гарз		2,823,188.73	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>622,748,172.33</b>	<b>397,664,865.50</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		622,748,172.33	397,664,865.50
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>426,967,128.07</b>	<b>552,491,800.69</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		-	<b>3,900,000,000.00</b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>		-	1,400,000,000.00
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-	2,500,000,000.00
Бусад		-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		-	<b>2,500,000,000.00</b>
Төлсөн ноогдол ашиг		-	2,500,000,000.00

**МӨНХ ДААТГАЛ ХХК****АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН – 2024 оны 12 сарын 31**

<i>Төгрөгөөр</i>	<b>Тод руулга</b>	<b>2023.12.31</b>	<b>2024.12.31</b>
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйгээний дүн		-	1,400,000,000.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		<u>176,350,096.02</u>	<u>1,067,355,170.13</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		<u>244,287,942.99</u>	<u>420,638,039.01</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		<u>420,638,039.01</u>	<u>1,487,993,209.14</u>